

MORE STEP Newsletter

MORE STEP – Mobility at risk: Sustaining the Mongolian Steppe Ecosystem

Newsletter No. 8

www.morestep.org

December 2024

Introduction of the thematic group: Regional Economics and Policy Analysis



© Chair of Ecosystem Services

Editorial

Welcome to our eighth newsletter! MORE STEP is a collaborative and interdisciplinary research project implemented by Mongolian and German partners and funded by the German Federal Ministry of Education and Research.

Background

Herders have been increasingly adopting sedentary lifestyles. This is of great concern because their ability to adapt to a dynamically changing environment is crucial for the resilience of the ecological system and, ultimately, herders' livelihoods (Fernández-Giménez et al. 2018).

Responding to these concerns, Mongolian policymakers have implemented new land use and management policies, including:

- *Leasing and certification of land* – land for winter and spring camps can be leased and certified to individual herding households.
- *Pasture monitoring and pasture use planning* – municipal administrations monitor pastures and develop plans to organise herders' movement that consider animal pasture capacities and stocking rates.

The researchers of the International Institute Zittau, TUD Dresden University of Technology investigated in what ways the herders' collective choices regarding seasonal and *otor* mobility are complementary to herders' choices to support or resist these land use and management policies.

Results


Herders in our study area struggled to coordinate their seasonal and *otor* mobility. According to a municipal expert on land use interviewed in our study area, “*the reason why people do not want to move is that they are afraid to lose their land to others*”.

We also learned that most herders supported the policy of leasing and certification of land for winter and spring camps due to associated benefits, but they resisted policies for pasture use planning. The latter was due to a lack of coordination and enforcement.

However, we also observed some herding households that selected mobile herding strategies and complied with the pasture use planning policy. These pasture users benefited by improving their knowledge about the consequences of previous actions, establishing platforms for negotiating and cooperating in pasture use as well as excluding external actors from land access.

Take home message

Pasture use planning based on pasture monitoring has the potential to be complementary and support herders' mobility. This promising combination of policy instruments should be further developed and enforced. Additionally, herders can be incentivised to follow pasture use plans.



Examples of herders' mobility in the study area
(MORE STEP household survey 2019; participatory mapping by Lukas Drees and design by Alybek Ismailov)

For questions: please contact Dr. Ulan Kasymov
(ulan.kasymov@tu-dresden.de)

Original article: Kasymov, U., Ring, I., Gonchigsumlaa, G., Dejid, N., Drees, L. (2023). Exploring complementarity among interdependent pastoral institutions in Mongolia. *Sustainability Science* 18, 115–131.
<https://doi.org/10.1007/s11625-022-01198-9>

Reference: Fernández-Giménez, et al. 2018. Using an Integrated Social-Ecological Analysis to Detect Effects of Household Herding Practices on Indicators of Rangeland Resilience in Mongolia. *Environmental Research Letters* 13 (7), 075010.
<https://doi.org/10.1088/1748-9326/aacf6f>

MORE STEP МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

МОРЕ СТЭП – НҮҮДЭЛ, ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ЭРСДЭЛД: Монгол орны тал хээрийн экосистемийн тогтвортой байдлыг хадгалах нь

Мэдээллийн товхимол №8

www.morestep.org

Арванхоёрдугаар сар, 2024

БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСАГ, БОДЛОГЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ



© Chair of Ecosystem Services

Редакцийн зурвас

Бидний бэлтгэсэн ээлжит мэдээллийн товхимолыг хүлээн авна уу! МОРЕ СТЭП нь ХБНГУ-ын Засгийн Газрын Боловсрол, Судалгааны Яамны санхүүгийн дэмжлэгтэйгээр Монгол, Герман хоёр орны хамтран хэрэгжүүлж буй салбар хоорондын судалгааны төсөл юм.

Өмнөтгол

Малчид суурин амьдралын хэв маягийг сонгох үзэгдэл нэмэгдсээр байгаа нь эмзэглүүштэй. Учир нь малчдын хүрээлэн буй орчныхоо өөрчлөлтөд дасан зохицох чадвар нь тал нутгийн экосистемийн тогтвортой байдал төдийгүй тэдний амь амьжиргаанд нэн чухал үүрэгтэй (Fernández-Giménez et al. 2018).

Үүний эсрэг Монгол Улсын Засгийн Газар, хууль тогтоох байгууллага шинээр газар ашиглалт, менежментийн бодлогуудыг батлан хэрэгжүүлж байна. Тухайлбал:

- Газар эзэмших, ашиглах эрх – малчин өрхүүд өвөлжөө, хаваржааны бэлчээрийг ашиглах, эзэмших эрх нээгдсэн.
- Бэлчээр ашиглалтын хяналт, зохицуулгын журам – нутгийн захиргаа, удирдлагын газраас бэлчээрийн даац ба малын тоо толгойд үндэслэн бэлчээрийн газрыг хянах, малчдын нүүдэл, шилжилтийг зохицуулах болсон.

Дрездений их сургуулийн Циттау олон улсын судалгааны хүрээлэнгийн эрдэмтэд малчид улирлын болон отор нүүдэл хийх шийдвэрээ хамтран гаргах нь эргээд тэдний газар ашиглалт, менежментийн бодлогыг дэмжих эсэхэд ямар нөлөөтэйг судалжээ.

Үр дүн


Судалгаанд хамрагдсан малчид улирлын болон отор нүүдлээ зохицуулахад хүндрэлтэй байдаг тухайгаа илэрхийлсэн юм. Үүн дээр орон нутгийн захиргааны мэргэжилтний нэмж хэлснээр, “малчид нүүхээ больсон нь бэлчээрийн газраа бусдад алдах вий гэх айдастай холбоотой” аж.

Түүнчлэн малчдын дийлэнх нь өвөлжөө, хаваржааны бэлчээрийг эзэмших, ашиглах эрхийн ач тусыг сайшаан дэмжсэн боловч бэлчээр ашиглалтыг зохицуулах журмыг хэрэгжилт муутай гэж үзэн эсэргүүцэх хандлагатай байв.

Гэсэн хэдий ч зарим малчин өрх нүүдлийн мал маллах стратегийг хэрэгжүүлж, уг бодлогыг дагаж мөрдөж буй жишиг ажиглагдсан. Эдгээр өрхүүд урьд нь бэлчээр ашиглахдаа гаргадаг байсан алдааныхаа үр нөлөөг ойлгохын зэрэгцээ хоорондоо тохиролцож, хамтран бэлчээрийн газраа ашиглах нөхцөл бүрдсэн зэрэг давуу талыг олж авчээ. Мөн зөвхөн тухайн орон нутгийн малчид бэлчээрийн газрыг ашиглах боломж нээгдсэн байна.

Дүгнэлт

Бэлчээрийн хяналт дээр суурилсан бэлчээр ашиглалтын төлөвлөлт, зохицуулгын бодлого нь малчдын нүүдлийг нэмэгдүүлэхэд туслах чухал ач холбогдолтой. Иймд энэхүү бодлогыг цаашид улам хөгжүүлж, хэрэгжүүлэхэд анхаарах нь зүйтэй. Тухайлбал, малчдыг урамшуулах нь бэлчээр ашиглалтын бодлогыг хэрэгжүүлэхэд үр дүнтэй алхам байж мэдэх юм.



Судалгааны бус дэх малчдын нүүдлийг харуулсан зураглал (МОРЕ СТЭП өрхийн судалгаа 2019; хамтын оролцоот зураг зүйн аргаар хийсэн загварчлал (Drees, L and Ismailov, A)

Дэлгэрэнгүй мэдээлэл: Др. Улан Казимовтой ulan.kasymov@tu-dresden.de хаягаар холбогдоно уу.

Эх сурвалж: Kasymov, U., Ring, I. Gonchigsumlaa, G., Dejid, N., Drees, L. (2023). Exploring complementarity among interdependent pastoral institutions in Mongolia. Sustainability Science 18, 115–131. <https://doi.org/10.1007/s11625-022-01198-9>

Нийтэлэл: Fernández-Giménez, et al. 2018. Using an Integrated Social-Ecological Analysis to Detect Effects of Household Herding Practices on Indicators of Rangeland Resilience in Mongolia. Environmental Research Letters 13 (7), 075010. <https://doi.org/10.1088/1748-9326/aacf6f>